

МОНГОЛ-ХЯТАДЫН ХИЛ ОРЧМЫН БҮС НУТГИЙН ХАРИЛЦАА: СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН АСУУДАЛД

Ч.БАТЦЭЦЭГ*

Аливаа улс орны гадаад бодлого хөрш орноос эхэлдэг жамтай. Хөрш БНХАУ нь манай орны хөгжлийн чухал хүчин зүйлийн нэг мөн гэж бид үздэг учраас бүс нутгийн асуудал БНХАУ-тай салшгүй холбоотой юм. Орчин үед бүс нутгийн тухай ойлголт нийгэм, цаг үеийн хувирлыг дагаад байнга өөрчлөгдөж байна. Гэсэн хэдий ч улс орон бүр эдийн засгаа голлон хөгжүүлэх үүднээс дотооддоо бүсчилэн хувааж, гадаад бодлогынхоо хүрээнд мөн гадаад ертөнцийг бүсчилэн авч үзсээр байна.

Монгол Улсын Их Хурлаас “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг 2001 онд баталж¹, эдийн засгийн бүсчилсэн хөгжлийнхөө хөтөлбөрийг хил орчмын бүс нутаг хоорондын хамтын ажиллагаатай уялдуулах зорилго тавьсан. Үүний тулд Монголын эдийн засгийг бүхэлд нь Зүүн бүсийн нутгаар дамжуулан Зүүн болон Зүүн хойт Азийн орнуудтай хоршин хөгжүүлэх гол чиглэл болгох, Баруун бүсээр дамжуулан Хятад, Орос, Казахстан, Европын Холбооны Улс, Төв Ази, Дундад Ази, Ойрхи Дорнодын орнуудын худалдаа, эдийн засгийн сүлжээнд холбогдох, Хангайн болон Төвийн бүсийг Орос, Хятадын зах зээлийн багтаамжид түшиглэн Ази, Европыг холбосон хөгжлийн замтай уялдуулах гарцыг илрүүлж, бүс нутгийг холбон зохицуулах чиглэлээр ажиллах; Зүүн хойт Азийн орнуудын хувьд Монголын Зүүн бүсийн Чойбалсан, Сүмбэр, Нөмрөгийн чиглэлээр Номхон далайн бүс нутгийн орнуудтай холбох тээврийн хонгилийг /коридор/ нээх боломжийг судлах асуудлыг чухалчилж байна.²

Монгол, Хятад хоёр орны хил орчмын бүс нутгийн харилцаа хамтын ажиллагаа бол нэн эртний уламжлалтай. Аливаа улс орны бүс нутгийн харилцаа, хамтын ажиллагаанд хилийн дагуу оршин суух ижил төстэй үндэстнүүдийн

* Ч.БАТЦЭЦЭГ- ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

¹ http://www.mofa.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=151:2009-05-04-03-32.

² “Олон улс судлал” сэтгүүл. 2010№1,2 т.17

нийтлэг зүйл, давуу тал чухал ач холбогдолтой байдаг. Бүс нутгийн харилцаа нь улс төрийн гэхээсээ илүү эдийн засаг-худалдаа, соёл-хүмүүнлэгийн хүчин зүйлд тулгуурладаг хөрш орнуудын хөгжлийн чухал зүй тогтол, үйл явц юм.

Манай улсын зүүн хил орчмын бүс нутгийн харилцаа, хамтын ажиллагаанд хоёр хөрштэй хиллэдэг Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймаг нь газарзүйн байршлаараа чухал ач холбогдолтойд тооцогддог. Эдгээр аймаг нь хил залгаа 6 боомтыг түшиглэн гадаад харилцаагаа хөгжүүлэх, зах зээлийн багтаамжаа өргөжүүлэх бүрэн боломжтой. Тухайлбал: ОХУ-ын Өвөр Байгалийн хязгаар, БНХАУ-ын зүүн хойд нутаг Хар мөрөн, Гирин, Ляонин болон ӨМӨЗО-ы Хөлөнбуйр, Хянган, Шилийн гол аймаг, Манжуур хоттой харилцаа холбоотой байж хамтын ажиллагаагаа идэвхжүүлж байна.

Геополитикийн үүднээс авч үзвэл, хил орчмын бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэх нь хил, гаалийн дэд бүтцийг бий болгохоос эхэлнэ. Өнөөгийн байдлаар, Манжуур хотод гурван улсын хил орчмын боомтын худалдааны чөлөөт бүс байгуулах, гурван улсын хилийн цэг дээр гаалийн чөлөөт бүс байгуулах асуудлыг хэлэлцэж, санал солилцож, санамж бичигт гарын үсэг зурсан байна. Манай хоёр орны хил орчмын бүс нутгийн хамтын ажиллагаа идэвхжиж, цаашид улам өргөжин тэлэх хандлагатай болж байна. Хоёр орны хил орчмын бүс нутгийн харилцаа гол төлөв гадаад худалдаа, аялал жуулчлал, соёл-хүмүүнлэгийн харилцаа, орон нутгийн боловсролын солилцоо гэх зэргээр хүрээгээ тэлж, улмаар байгаль орчны хамгаалал, хөдөө аж ахуй, гал түймэртэй тэмцэх байгууллагын хамтын ажиллагааны чиглэл нэмэгдсээр байна.

Одоо хил орчмын бүс нутаг хоорондын соёл-хүмүүнлэг, аялал жуулчлалын салбарын харилцаа, хамтын ажиллагааны тухайд авч үзье.

Өнөөдөр Монгол Улсын гадаад харилцаа, хамтын ажиллагаанд монгол үндэснийхээ соёлын нөлөөллийг идэвхжүүлж, гадаад шинэ зах зээлийг эрэлхийлж, соёлын бренд бүтээгдэхүүн бий болгох, соёлын аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх шаардлага тавьж байгаа. Ийм үед Монгол, Хятад хоёр улсын соёл боловсролын салбарын харилцаа, хамтын ажиллагаа ялангуяа 2010 он гарсаар улам идэвхжиж

байна. 2010 оны 5 дугаар сард хоёр орны засгийн газар Улаанбаатар, Бээжин хотод харилцан соёлын төв нээх тухай болон 2010-2013 онд хэрэгжүүлэх соёлын солилцооны төлөвлөгөөнд гарын үсэг зурсан байна. Улмаар 2010 онд Монголд Хятадын соёлын төвийг нээж, Монгол Улс Хятадад “Монголын соёлын жил”-ийн ажиллагааг эхлүүлсэн бөгөөд 2012 оны 3 дугаар сарын сүүлчээр Бээжин хотноо Монголын “соёлын өдрүүд”-ийн нээлтийн ажиллагаа болж, бүтэн сарын турш амжилттай үргэлжиллээ.

Өнөөгийн байдлаар БНХАУ-ын 60 гаруй хотод 7000-аад монгол оюутан суралцаж байгаагаас БНХАУ-ын Засгийн газрын тэтгэлгээр 2000 оюутан суралцаж байна. Мөн ӨМӨЗО-нд манай 2000 оюутан сурч байгаагийн 47 хувь нь Өвөр Монголын Засгийн газрын тэтгэлгээр суралцаж байна. Ийнхүү хүүхэд залуусын солилцоог бэхжүүлэх нь хоёр улсын харилцааны ирээдүйн хөгжилд стратегийн чухал ач холбогдолтой юм.

Манай хоёр орны хил орчмын бүс нутгийн хоорондын харилцаа, ард иргэдийн дунд хэрэгжиж буй үйл ажиллагаанд ч соёл урлагийн салбарын хамтын ажиллагаа томоохон байр суурь эзэлдэг. Монгол, Орос, Хятад гурван улсын бүс нутгийн хамтын ажиллагаанд олон улсын эдийн засгийн форум, олон улсын үзэсгэлэн-худалдаа, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх бизнес-уулзалт, “Гоо бүсгүй” шалгаруулах тэмцээн, “Хятад дууг хэн сайн дуулах вэ” уралдаан гэх зэрэг арга хэмжээ, урлаг соёлын үйл ажиллагаа тогтмол явагдаж байна. Үүнийг Монгол Улсын Дорнод, Сүхбаатар аймгаар жишээ болгон авч үзэж болно. Тухайлбал: Дорнод аймаг ӨМӨЗО-ы Хөлөнбуйр, Хянган аймагтай, Сүхбаатар аймаг нь БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийнгол аймаг, Зүүн Үзэмчин хошуу, Хөлөнбуйр зэрэг аймагтай шууд харилцаж, янз бүрийн үйл ажиллагаа явуулж байна. Сүхбаатар аймаг 2004 оноос БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймагтай боловсролын салбарын хамтын ажиллагаа өрнүүлж, оюутан сурагчдын солилцоо явуулж байгаа ажээ.

Ийнхүү орон нутгийн хамтын ажиллагаа нь хоёр улсын харилцааны чухал хэсэг болж, ихээхэн үүрэг гүйцэтгэж байгааг тэмдэглэх хэрэгтэй. Цаашид манай улс соёлын салбараа бүсчилсэн хөгжлийн тогтолцоонд шилжүүлж, хөдөө орон нутгийн ард иргэдийн соёлын үйлчилгээг хүртээмжтэй, чанартай болгох, соёлын

биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчдыг хамгаалах, дэмжих, соёлын аж үйлдвэрлэл, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд гол анхаарлаа хандуулж байна.

Нөгөөтэйгүүр 2011 онд Монгол Улс, БНХАУ-ын хооронд стратегийн түншлэлийн харилцаа тогтоосон явдал манай хоёр орны хувьд ихээхэн чухал ач холбогдолтой боллоо. Монгол-Хятадын стратегийн түншлэлийн харилцааны нийгмийн үндэс суурийг бэхжүүлэх болон харилцан ойлголцол, найрсаг хандлагыг улам нэмэгдүүлэхэд хүмүүнлэгийн салбарын харилцаа, хоёр орны ард түмний солилцоо өдрөөс өдөрт гүнзгийрэн, идэвхжиж байгаа явдал чухал ач холбогдолтой юм. 2009 онд БНХАУ-д зорчсон монголчуудын тоо давхардсан үзүүлэлтээр 760-аад мянга байсан бол Монгол Улсад зорчсон хятад иргэд 212 мянгад хүрчээ³. Үүнтэй уялдуулан хилийн шалган нэвтрүүлэх боомтуудын тохижилт, тоног төхөөрөмж, үйл ажиллагааг нь боловсронгуй болгох, зорчигч иргэдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай үйлчилгээг анхаарах явдал нэн чухал болж байна.

Аялал жуулчлал нь Монгол Улсын эдийн засгийн голлох салбаруудын нэг мөн. Монгол Улсын аялал жуулчлалын салбарынхан мөн бүс нутаг, бүсчилсэн асуудлыг өөрийн салбарын онцлогт тулгуурлан тогтоодог. Үүнд: аялал жуулчлалын бүс нутагт аялал жуулчлалын бүтээгдэхүүн болох байгалийн үзэсгэлэнт газрууд, түүх соёлын дурсгалууд, амралт сувиллын нөөцүүдийн төвлөрсөн байдал болон нийгмийн дэд бүтцийн түлхүү хөгжлийн давуу талыг түшиглэн аялал жуулчлалын өөрийн өөрийн онцлог үйлчилгээний ялгааг харгалзан хөгжих чиглэлийг баримталж ирлээ.

2008 онд Монгол Улсын Засгийн газрын бүтцийн өөрчлөлтөөр Байгаль орчин, аялал жуулчлалын яам байгуулагдаж, улмаар 2007-2011 онд аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах хөгжлийн бодлого, стратегийн төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулсан байна. Монгол Улсын Засгийн газар аялал жуулчлалыг үндэсний эдийн засгийн тэргүүлэх салбаруудын нэг болгон хөгжүүлэх зорилт дэвшүүлэн ажилласны үр дүнд жуулчдын тоо 2011 онд 450000-д хүрсэн

³ “Монгол-Хятадын харилцаа жарнаас жаранд” Улаанбаатар 2010 он, 28-р тал.

байна.⁴ /Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас зөвлөмж болгосон аргачлалын дагуу тооцоолсноор/. Одоогоор манай улсад ирж байгаа жуулчдын дийлэнхи олонхийг буюу 92 хувийг БНХАУ, ОХУ, БНСУ, Япон, АНУ, ХБНГУ, Австрали зэрэг 10-аад орны жуулчид бүрдүүлж байна.

БНХАУ манай орныг хятадын жуулчид өөрийн зардлаар жуулчлах орны жагсаалтанд оруулж, Хятадаас бүлэг жуулчдыг хүлээн авах эрхтэй болсон нь энэ салбар эрчимтэй хөгжих нааштай хандлагын эхлэл болжээ. Нөгөөтэйгүүр БНХАУ-д ирэх жуулчдын тоо жил бүр 8 хувиар өсөх төлөвтэй байгаа нь Монголд ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх таатай боломж юм. 2010 оны байдлаар, Монгол Улсад нийт 456303 гадаадын жуулчин ирснээс хамгийн олон буюу 193730⁵ жуулчин БНХАУ-аас иржээ. Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын газар болон БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах орны Аялал жуулчлалын товчоо хамтран 2006 оноос хойш жил бүр “Хилийн бүсийн аялал жуулчлалыг зохицуулах хурал” зохион байгуулж, тогтмолжуулсан байна. Энэ уламжлалт хурлаар тухайн жилийн хамтын ажиллагааг хоёр тал дүгнэж, дараа онд шийдвэрлэх асуудлаа хэлэлцэн төлөвлөдөг байна. 2010 онд БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хөх хотод “Хилийн бүсийн аялал жуулчлалыг зохицуулах 5-р хуралдаан”, мөн 2009 онд Улаанбаатар хотод уг хуралдааныг зохион байгуулж, хурлын протоколын хэрэгжилтийг дүгнэж, хоёр талын аялал жуулчлалын хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлаар протоколд гарын үсэг зурсан байна. Мөн ӨМӨЗО-ы Аялал жуулчлалын товчооны дарга тэргүүтэй төлөөлөгчдийг Монгол Улсад хүлээн авч ээлжит хуралдааныг зохион байгуулжээ.

Нөгөөтэйгүүр Монгол, Орос, Хятадын хооронд “Цайны зам” төслийг хэрэгжүүлж эхлээд байна. Энэ төслийн хүрээнд гурван улсын аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагааны хүрээг тэлэх, гурван улс дамнасан аяллын шинэ маршрут–чиглэлийг хөгжүүлэх, улмаар аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн болгон олон улсын хэмжээнд зарлах зэрэг асуудлыг судалж байна. Энэ ажлын

⁴ “Аялал жуулчлал ба өрсөлдөх чадвар-2011” Үндэсний зөвлөлгөөний материалаас. Улаанбаатар хот

⁵2011 онд Улаанбаатар хотод болсон олон улсын эрдэм шинжилгээний хурлын материалаас. “Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, төрөөс баримталж байгаа бодлого”

хүрээнд 2010 оны 1 дүгээр сарын 31-нээс 2010 оны 3 дугаар сарын 4-нд Монгол, Орос, Хятад гурван улсын “Өвлийн цайны жин” туршилтын төслийг Хөх хот – Эрээн - Замын-Үүд – Улаанбаатар – Алтанбулаг – Хиагт - Улаан-Үд - Эрхүүгийн чиглэлд хэрэгжүүлжээ. БНХАУ-тай хоёр талын зохион байгуулж байгаа аялал жуулчлалын сурталчилгааны арга хэмжээ, үзэсгэлэн яармагт идэвхтэй оролцохоор тохиролцсоны дагуу БНХАУ-ын талаас 2011 онд Тяньжин хотод болсон аялал жуулчлалын үзэсгэлэнд, Монголын талаас Улаанбаатар хотод зохиогдох аялал жуулчлалын үзэсгэлэнд тус тус оролцжээ.

Монгол Улсын аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдлыг харахад харьцангуй хөгжиж, жуулчдын тоо өсч байгаа хэдий ч БНХАУ-ын аялал жуулчлалын салбарын хөгжлөөс хол зөрүүтэй байна. БНХАУ нь аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхийн тулд дэд бүтцийн бүтээн байгуулалтыг бүрэн шийдвэрлэсэн байдаг. Мөн түүнчлэн Хятадад хүн амын олноос улбаалан дотоодын аялал жуулчлал маш эрчимтэй хөгжиж байна. Харин манай улсын хувьд дэд бүтцийн хөгжлийн байдал харьцангуй сул дорой, тээврийн болон байршлын хэрэгслийн хүчин чадал нь аялал жуулчлалын оргил ачааллын үед хүрэлцээ муутай, аялал жуулчлалын үйлдвэрлэл нь улирлын шинжтэй байдаг. Нөгөөтэйгүүр манай улс аялал жуулчлалын тухай хуулийг шинэчлэн найруулах, жуулчны үйлчилгээний байгууллагуудын хариуцлагыг дээшлүүлэх, үйлчилгээний нэр төрөл, хэлбэр тэдгээртэй холбогдох харилцааг зохицуулах, төр орон нутгийн захиргааны байгууллагуудын эрх үүргийг тодорхой болгох шаардлага гарч байгаа.

Бид хөрш орныхоо туршлагаас судлаж, улс, орон нутгийнхаа давуу талыг түшиглэсэн аялал жуулчлалыг өргөжүүлэн хөгжүүлэхийн тулд нэн түрүүнд хил орчмын дэд бүтцийг сайжруулах ажлыг эрчимжүүлэх явдал маш чухал. БНХАУ-ын талаас хилийн бүсэд аялал жуулчлалыг цогцолбороор нь хөгжүүлэхэд хамтран ажиллах санал тавьдаг байна. Тухайлбал: Зүүн хатавч, Ар хашаат боомтод Монголын хилийн бүсийн аялал жуулчлалын маршрут бий болгох саналаа 2010 онд ӨМӨЗО-ы Хөх хотод болсон “Хилийн бүсийн аялал жуулчлалыг зохицуулах хурал”-ын үеэр илэрхийлж байжээ. Ийнхүү хөрш орнуудтай аялал жуулчлалын зах

зээл дээр идэвхтэй хамтран ажиллах шаардлага гарч байгааг хоёр талын хүчин чармайлт, хамтын ажиллагаагаар шийдвэрлэвэл зохилтой.

Аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаа нь эдийн засгийн хувьд маш үр ашигтайгаас гадна ажлын байр бий болгох, ДНБ-ийг өсгөн нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд байгаль орчноо хамгаалах, нийгэм соёлын өв баялагаа бататгах, нөхөн сэргээхэд нэн чухал үүрэгтэй. Иймээс бүс нутгийг хөгжүүлэх, орон нутгийн ард иргэдийг аялал жуулчлалд татан оролцуулж, аялал жуулчлалын талаархи сургалт, сурталчилгаа явуулж, мэргэжилтэй боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлэх, хүний нөөцийн хангамж, хүрэлцээ дулимаг байгааг нэн даруй сайжруулах явдал чухал юм.

Орон нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалт бага шаардсан үндэсний уламжлал, ёс заншлыг түшиглэсэн эко цогцолборыг бий болгох, аялал жуулчлалын дагалдах бизнес болох гар урлал, бэлэг дурсгал, орон нутгийн брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг төрөөс дэмжих, экспортын үйлдвэрлэлд үзүүлэх хөнгөлөлтөнд хамруулах нь салбарын эдийн засгийн боломжийг сайжруулах нөхцөл болох аж. Ялангуяа сүүлийн үед соёлын өв, музей, концерт, урлагийн наадам үзэх, соёл урлагийн арга хэмжээнүүдэд оролцохоор янз бүрийн орныг зорих жуулчдын тоо жилээс жилд нэмэгдэж байна. Энэхүү соёлын аялал жуулчлал нь аялал жуулчлалын бас нэг төрөл болж эрчимтэй хөгжиж байгаа явдал нь манай хоёр орны хил орчмын бүс нутгийн хоорондын урлаг соёл болон аялал жуулчлалын салбарын харилцаа, хамтын ажиллагааг нэгтгэж явуулах сайхан боломжийг нээж өгч байгаа юм.

Ийнхүү Монгол, Хятад хоёр улсын зүүн бүсийн аймгуудын хоорондын худалдаа, соёл, аялал жуулчлалын харилцаа, хамтын ажиллагаа өдрөөс өдөрт өргөжин тэлж байна. Цаашид энэ харилцаа хамтын ажиллагаагаа шинэ шатанд гаргах нь улс орныхоо эдийн засгийн хөгжлийн боломжийг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой. Чингэхдээ алслагдсан нутаг орныг хооронд нь уялдуулж, дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалт хийхийн тулд Монгол, Орос, Хятад гурван талын хамтарсан бодитой хөрөнгө оруулалт хийх явдал чухал болж байна.